



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 06 сарын 14 өдөр

Дугаар А/166

Улаанбаатар хот


Ажлын хэсэг байгуулах тухай

Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Нийслэлийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн “Нийслэлийн 2018-2019 оны өвөлжилтийн дүн, 2019-2020 оны өвөлжилтийн бэлтгэл хангах тухай” А/503 дугаар захирамж, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн 2019-2020 оны өвөлжилтийн хугацаанд гарч болзошгүй гэмтэл саатлаас урьдчилан сэргийлэх, зайлшгүй засварлах шаардлагатай эмнэлэг, сургууль, цэцэрлэг болон бусад төрийн өмчийн барилга байгууламжийн дээвэр, инженерийн шугам сүлжээнд үзлэг шалгалт хийх үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралт ёсоор байгуулсугай.


2. Өвөлжилтөд хүндрэл учруулж болзошгүй эмнэлэг, сургууль, цэцэрлэг болон бусад төрийн өмчийн барилга байгууламжийн дээвэр, инженерийн шугам сүлжээнд үзлэг шалгалт хийх ажлын хэсгийн удирдамжийг хоёрдугаар хавсралт ёсоор баталсугай.

3. Дээрх үзлэг шалгалтын үр дүнг Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулж хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэхийг ажлын хэсэг /Т.Хэрлэн/-т үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн
А/66 тушаалын дүрээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ахлагч:	Т.Хэрлэн	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн дарга
Гишүүд:	Ж.Ганболд	Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга
	Б.Отгонхүү	Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга
	Б.Эрдэнэчимэг	Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газрын Дэд бүтэц, үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн дарга
	Д.Хүрэлбаатар	Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга
	Ц.Тунгалаг	Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга
	Т.Эдмон	Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга
	Н.Мөнгөн-Эрдэнэ	Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга
	Ц.Бат-Эрдэнэ	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга
	А.Гэрэлт-Од	Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга
	З.Отгонбаяр	Нийслэлийн Эрүүл мэндийн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
	Р.Даваасүрэн	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Б.Отгонбат	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн
	Э. Баярмагнай	Нийслэлийн Боловсролын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
Д.Ирмүүнзаяа	Нийслэлийн Боловсролын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн	
Г.Одончойжав	Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар /ОНӨААТҮГ/-ын Ерөнхий инженер	
Нарийн бичгийн дарга:	О.Батмөнх	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн
1166 дугаар тушаалын дугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН ХАРЬЯА ЭМНЭЛЭГ, СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГҮҮДИЙН
2019-2020 ОНЫ ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ ХАНГАХ
УРЬДЧИЛСАН ҮЗЛЭГИЙН УДИРДАМЖ

2019 оны 06 сарын 13

Улаанбаатар хот

Нэг. Ажлын зорилго

1.1. Нийслэлийн 9 дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа Нийслэлийн харьяа эмнэлэг, сургууль, цэцэрлэг болон бусад төрийн өмчийн байгууллагуудын өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын явц, өнөөгийн байдалтай танилцаж дүн шинжилгээ хийх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулж, хотын Ерөнхий менежерийн зөвлөлд танилцуулах, улмаар Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн асуудлыг шийдвэрлүүлэхэд оршино.

1.2. Үйл ажиллагаанд хамрагдах байгууллага, нэгж, хуулийн этгээд

Нийслэлийн 9 дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа дүүргийн эмнэлэг, сургууль, цэцэрлэг болон бусад төрийн өмчийн байгууллага хамрагдана.

1.3. Эрх зүйн үндэслэл

- Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль,
- Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль,
- Нийслэлийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн "Нийслэлийн 2018-2019 оны өвөлжилтийн дүн, 2019-2020 оны өвөлжилтийн бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай" А/503 дугаар захирамж
- Холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журам

Хоёр. Ажлын чиглэл, зохион байгуулалт

2.1. Нийслэлийн 9 дүүргийн нутаг дэвсгэрт байрлах эмнэлэг, сургууль, цэцэрлэгүүдийн өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын явц, өнөөгийн байдалтай газар дээр нь үзэж танилцах, 2019-2020 оны өвөлжилтийн бэлтгэл хангахад инженерийн шугам сүлжээнд тулгарч буй хүндрэлтэй асуудлыг судлан дүн шинжилгээ хийж цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулах ажилтай холбоотой шаардлагатай мэдээ, мэдээлэл, баримтуудыг бүхий л хэлбэрээр /цаас цахим, баримтжуулсан зураг, бусад/ дараах байгууллагуудаас гаргуулан авна. Үүнд:

- Нийслэлийн Боловсролын газар,
- Нийслэлийн Эрүүл мэндийн газар
- Нийслэлийн Багануур дүүрэг,
- Багахангай дүүрэг,

- Баянгол дүүрэг,
- Баянзүрх дүүрэг,
- Налайх дүүрэг,
- Сонгинохайрхан дүүрэг,
- Сүхбаатар дүүрэг,
- Хан-Уул дүүрэг,
- Чингэлтэй дүүрэг
- Холбогдох эмнэлэг, сургууль, цэцэрлэг, бусад байгууллага

2.2. Ажлын хэсэг нийслэлийн Боловсролын газар, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа эмнэлэг, сургууль, цэцэрлэг болон бусад төрийн өмчийн байгууллагын өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын явц, өнөөгийн байдалтай газар дээр нь танилцах, объектод нэвтрэх, инженерийн шугам сүлжээтэй холбоотой мэдээллийг холбогдох албан тушаалтнаас авч болно.

2.3. Хугацаа:

Ажлыг 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдрөөс 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор явуулна. (Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн зөвлөлийн хуралд танилцуулна.)